

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДСЭНИЙ ТӨВ” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2017 оны 9 дугаар сарын 11 өдөр

№ 06

Улаанбаатар хот

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангасан байдал, цаашид авах арга хэмжээний тухай

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

...Эрчим хүчний системүүдийн 2017-2018 оны өвлийн их ачааллын үеийн горимыг тооцоолж төлөвлөж, боловсруулж салбарын ерөнхий инженерүүдийн зөвлөгөөнөөр 2017 оны 9-р сарын 7 –ны өдөр хэлэлцүүлэн батлууллаа.

2017 оны зуны бага ачааллын горимд тусгагдсаны дагуу станцууд төлөвлөгөөт бүрэн болон хэсэгчилсэн зогсолтуудаа хугацаанд нь хийсэн. Бүрэн зогсолтын үед горимын зохицуулалт болон шуурхай удирдлагаар хангаж ажиллалаа.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ажиллаж байгаа 5 ДЦС-уудын үндсэн тоноглолд хийгдэх их засварын ажлуудаас 4 ажил дуусаагүй ба 9-р сарын 06-ны өдрөөс 9-р сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд хийгдэхээр захиалга хийгдсэн байна.

Өмнөд бүсэд Ухаахудагийн ЦС, Даланзадгадын ДЦС-уудын үйл ажиллагаанд анхааран хүчдлийн горим хэвийн барих, дулаан хангамжийн хэвийн ажиллагааг хангахад хяналт тавьж ажиллаж байна.

ДБЭХС-ийн хувьд чадлын дутагдалтай байгаад анхааран өвлийн горимд Баруун-Урт болон Сүхбаатар аймгийн зарим сумдуудын хэрэглээг ТБНС-ээс хангаж ажиллахаар төлөвлөсөн.

Эрчим хүчний системүүдийн 2017 оны эрчим хүчний баланс хийх, төлөвлөгөө боловсруулж батлуулахаар ажиллаж байна... гэж тэмдэглэжээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гүйцэтгэх захирал Д.Балдорж, Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер Л.Бөхболд нарт үүрэг болгох нь:


1. Өвлийн их ачаалал эхэлсэнтэй холбоотойгоор нэгдсэн системийн хэмжээнд үндсэн тоноглолын их засварыг 10 дугаар сарын 15-ны дотор бүрэн дуусгах, дамжуулах, түгээх сүлжээний тоноглолд аваарийн захиалгаас бусад захиалгат засварыг хийлгэхгүй байх,

2. Салбарын ерөнхий инженерүүдийн зөвлөгөөнөөр баталсан өвлийн их ачааллын горимыг Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр мөрдүүлж ажиллах,

3. Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлалд өөрчлөлт оруулах асуудлыг ЭХЗХ-нд тавьж шийдвэрлүүлэх

4. Өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийг 91% гэжээ”.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ЧИМЭДДОРЖ